



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/60

Зуунмод

“Хөдөлмөрч манлай ахмад”-уудыг  
шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, Аймгийн Засаг даргын А/498 тоот захирамжаар батлагдсан “Хөдөлмөрч манлай ахмад шалгаруулж шагнах” журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Хөдөлмөрч манлай ахмад”-аар шалгарсан ахмадын нэрсийг нэгдүгээр хавсралтаар, “Хөдөлмөрч манлай ахмад”-ын шагналын зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн Хөдөлмөрч манлай ахмадуудыг тус бүр “Хөдөлмөрч манлай ахмад”-ын энгэрийн тэмдэг, үнэмлэх, 300,000 (гурван зуун мянга) төгрөгөөр шагнасугай.

3. Шагналын зардалд шаардагдах 3,130,000 (гурван сая нэг зуун гучин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Аймгийн Хөдөлмөрч манлай ахмадыг олон нийтэд сурталчлан алдаршуулж, хүндэтгэл үзүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр  
сарын 29 -ны өдрийн А/60 дүгээр  
захирамжийн 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН "ХӨДӨЛМӨРЧ МАНЛАЙ АХМАД"-ААР  
ШАЛГАРСАН АХМАДЫН НЭРС

№	Сумын нэр	Овог нэр	Улсад ажилласан жил	Аймагт ажилласан жил
1	Баянцогт	Дарам Сүхбаатар	41	41
2	Баянчандмань	Даваажав Алтанцэцэг	38	38
3	Баян-өнжүүл	Батсүх Пүрэв	39	39
4	Бүрэн	Чойжин Бунъя	32	32
5	Дэлгэрхаан	Дэмбэрэл Пүрэвсүрэн	36	36
6	Жаргалант	Содном Цэрэнбат	49	26
7	Заамар	Хасбат Булганбээ	48	29
8	Зуунмод	Жамбал Дуламсүрэн	42	42
9	Зуунмод	Ядамсүрэн Должинсүрэн	50	50
10	Цээл	Шагдарсүрэн Пүрэвсүрэн	51	51

оОо

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр  
сарын 29 -ны өдрийн А/60 дүгээр  
захирамжийн 2 дугаар хавсралт

ШАГНАЛЫН ЗАРДАЛ

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Мөнгөн шагнал	10ш	300.000	3.000.000
2	Хадаг	10ш	12.000	120.000
3	Үнэмлэх	1ш	10.000	10.000
	Нийт			3,130,000

ТӨСӨВ БОЛОВСРУУЛСАН:  
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН *Г.ЧАНЦАЛДУЛАМ* Г.ЧАНЦАЛДУЛАМ

ХЯНАСАН:  
ТӨСВИЙН ЗАРЛАГА ХАРИУЦСАН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН *Ж.ЭРДЭНЭЖАРГАЛ* Ж.ЭРДЭНЭЖАРГАЛ